БАТЛАВ:
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

А.ЭНХМАНЛАЙ

ГАЗРЫН ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ БОЛОН ГАЗРЫН ТӨЛБӨР ТАТВАРЫН ЦАХИМ СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар: А2/2024-06

Улаанбаатар хот

Д/Д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажлын үндэслэл	- Газрын тухай хуулийн 48[1] дугаар зүйлийн 48[1].7 дахь заалт; - Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйл - Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7.5 дахь заалт - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.3 дахь заалт; - "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.6.12 дахь заалт; - "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.4 дэх заалт; - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол - Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө:
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Газрын үнэлгээний цахим систем, Газрын төлбөр, татварын цахим системд холбогдох нэмэлт хөгжүүлэлтийг хийж, газрын үнэлгээ, дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнийн мэдээлэл боловсруулах, нөхөх олговор тооцоолох, төлбөр татварын ногдуулах, нэхэмжлэх үүсгэх, төлөлт шалгах үйл ажиллагааг боловсронгуй болгож үйл ажиллагааг бүрэн цахимжуулан хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд оршино.
3.	Хамрах хүрээ	Монгол Улсын хэмжээнд, Газрын үнэлгээний цахим систем, Газрын төлбөр, татварын цахим системд холбогдох нэмэлт хөгжүүлэлтийг хийх
4.	Гүйцэтгэх хугацаа	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд.
5.	Ажлын иж бүрдэл	1. Газрын үнэлгээний цахим системийн нэмэлт хөгжүүлэлт: - Дуудлага худалдааны анхны үнийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан тогтоол, аргачлалын дагуу тооцож, нэхэмжлэлийг үүсгэж, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх лавлагааг гаргаж үйл ажиллагааг бүрэн автоматжуулах; - Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх; - Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон нийт газарт дуудлага худалдааны анхны үнийг эрх бүхий

Д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
		этгээдийн шийдвэр, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан аргачлалыг үндэслэн тооцох модулийг хөгжүүлэх; - Дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн тооцож, нэхэмжлэхийг үүсгэх, төлбөр төлсөн эсэхийг шалгах, хяналт тавих модулийг хөгжүүлэх; - Газрын үнэлгээний цахим системээс дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх лавлагааг гаргах боломжийг бүрдүүлэх; - Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөх олговрын болон суурь үнэлгээг тогтоох үйл ажиллагааг бүрэн автоматжуулан хэрэглэгчдэд мэдээ, мэдээллээр үйлчлэх; - Иргэн, хуулийн этгээдэд газрын нөхөх олговор олгосон, тооцсон талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийн, мэдээллийн сан үүсгэх; - Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговор тооцох газрыг бүртгэж баталгаажуулан газрын нөхөх олговор олгох газрын хэмжээ, байршлыг газар зүйн мэдээллийн системийн дүн шинжилгээ (geoprocessing) хийх боломжийг бүрдүүлэх; - Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөх олговрын хэмжээ тогтоох, нөхөх олговрыг олгох үйл ажиллагааг бүртгэх модулийг хөгжүүлэх - Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг дүйцүүлэн олгох үйл ажиллагааг Газрын үнэлгээний цахим системээр эрхлэх боломжийг бүрдүүлэх; - Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөх олговрын болон суурь үнэлгээний лавлагааг гаргах боломжийг бүрдүүлэх; - Төлөвлөлтийн нэгж талбар бүрт газрын суурь үнэ, дуудлага худалдааны анхны үнийг тооцож, харуулах; - Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнд үндэслэн газрын зах зээлийн үнийн бүсчлэлийг харуулах; - Газрын үнэлгээний цахим системийн үйл ажиллагааг сайжруулж, ачааллын тэнцвэржүүлэн (load balance), бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлэх; - Захиалагчаар гаргасан саналын дагуу бусад нэмэлт хөгжүүлэлтийг цаг тухай бүр хийж гүйцэтгэх: 2. Газрын төлбөр, татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт: - Газрын төлбөр, татварын цахим системийн сервер, баазын ачааллыг бууруулж, байнгын нөөцлөх үйл ажиллагааг сайжруулж, ачааллын тэнцвэржүүлэн (load balance), бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлэх; - Ашигт малтмал, газрын тосны газраас баталсан уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Газрын төлбөрийн тухай хуулийн 7.4-т заасан төлбөрийн хувь хэмжээг тооцоолж, үйл ажиллагааг цахимжуулах;

Д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
		- УИХ-аас батлагдсан Улсын хилийн зурвас газрын хил заагийг Газрын төлбөр, татварын цахим системд оруулж, хилийн зурвас газарт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөр тооцож, Газрын төлбөрийн тухай хуулийн 8.1.3-т зааснаар газрын төлбөрт хөнгөлөлт, чөлөөлөлт тооцож ногдуулах модуль хөгжүүлэх; - Газрын төлбөр, татварын цахим системээс маш нууц давхаргад бүртгэлтэй цэргийн ангиуд болон холбогдох бусад газарт газрын төлбөрийг бодуулж, ногдуулах модулийг хөгжүүлэх; - Газрын төлбөр, татварын цахим системээс газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн тайлан /ГНСТ-8/-г маягтын дагуу гаргах; - Газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийн бодит цаг (real time)-аар шинэчлэлтийг хийж, төлөвийг өөрчлөх; - Газрын төлбөр, татвартай холбоотой статистик, тоон мэдээллүүд харах цэс (view) үүсгэх, төрөл бүрийн судалгааг /нэгж талбар тус бүрээр/ системээс олон төрлийн сонголттойгоор гаргах боломжийг бүрдүүлэх; 3. Системүүдийн баримт бичгийг шинэчилж, тайлан, гарын авлага боловсруулан захиалагч талд хүлээлгэн өгөх, баталгаат хугацаанд засвар үйлчилгээг хийж хэвийн үйл ажиллагааг хангах; - Системүүдийн баримт бичгийг эцсийн байдлаар шинэчлэн боловсруулах; - Хөгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгснөөс хойш 1 жилийн хугацаанд шаардлагатай нэмэлт засварыг цаг тухай бүрт нь хийх, хэвийн үйл ажиллагааг хангах; 4. Мэргэжилтэн албан хаагчдын чадавхжуулах, холбогдох сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах: - Газрын үнэлгээний цахим систем, Газрын төлбөр, татварын цахим системийн удирдлага (admin) хэсэгт ажиллах албан хаагчдын сургах; - 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны газрын үнэлгээ, төлбөр, газар чөлөөлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, чадавхжуулан мэргэжил арга зүйгээр хангах;
6.	Ажлын үр дүн	- Газрын үнэлгээний цахим систем, Газрын төлбөр, татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан байх. - Дуудлага худалдааны анхны үнийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан тогтоол, аргачлалын дагуу тооцож, нэхэмжлэлийг үүсгэж, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх лавлагааг гаргаж үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон байх; - Газрын нөхөх олговрын болон суурь үнэлгээг тогтоох үйл ажиллагааг бүрэн автоматжуулан хэрэглэгчдэд мэдээ, мэдээллээр үйлчлэх боломжтой болсон байх; - Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг дүйцүүлэн олгох үйл ажиллагааг

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
		Газрын үнэлгээний цахим системээр эрхлэх боломжийг бүрдүүлэх; - Газрын төлбөр, татварын цахим системийн үйл ажиллагааг сайжруулж, ашигт малтмал, газрын тосны газраас баталсан уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн төлбөрийн хувь хэмжээг тооцоолж, үйл ажиллагааг цахимжуулах; - Улсын хилийн зурвас болон маш нууц давхаргын мэдээлэлд үндэслэн иргэн, хуулийн этгээдэд олгогдсон нэгж талбарт газрын төлбөрийг бодуулж, ногдуулах модулийг хөгжүүлсэн байх; - Газрын төлбөр, татвартай холбоотой статистик, тоон мэдээллүүд харах цэс (view) үүсгэх, төрөл бүрийн судалгааг /нэгж талбар тус бүрээр/ системээс олон төрлийн сонголттойгоор гаргах боломжийг бүрдүүлэх; - Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнд үндэслэн газрын зах зээлийн үнийн бүсчлэлийг харуулах; - Газрын үнэлгээний болон Газрын төлбөр, татварын цахим системийн үйл ажиллагааг сайжруулж, ачааллын тэнцвэржүүлэн (load balance), бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлэх; - Системүүдийн баримт бичгийг шинэчилж, тайлан, гарын авлага боловсруулан захиалагч талд хүлээлгэн өгөх, баталгаат хугацаанд засвар үйлчилгээг хийж хэвийн үйл ажиллагааг хангах; - Төлөвлөлтийн нэгж талбарт дуудлага худалдааны анхны үнэ, - Мэргэжилтэн албан хаагчдын чадавхжуулах, холбогдох сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах;
7.	Боловсруулах үе шат	1. Системийн нэмэлт хөгжүүлэлттэй холбоотой, техникийн шийдлийг тодорхойлох 2. Үндсэн үйл ажиллагааны дараалал болон процессын зураглалыг гаргах. 3. Холбогдох мэдээллийн сан үүсгэж, цахим системийн хөгжүүлэлтийг хийх, захиалагчийн саналын дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх 4. Системийн туршилт, зүгшрүүлэлт хийх 5. Захиалагч талд хүлээлгэн өгөх
8.	Техникийн шаардлага	- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг өндөр түвшинд шийдсэн байх; - Төрийн нууцыг хадгалах, хамгаалах хууль болон дүрэм, журмыг баримтлан ажилласан байх; - Цахим системийг ашиглахад энгийн, хялбар болсон байх; - Холбогдох мэдээллийн сантай холбогдож иргэн, хуулийн этгээдэд түргэн, шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон байх; - Мэдээллийн чанар орон зайн мэдээллийн дэд бүтцийн өгөгдлийн стандарт шаардлагыг хангасан байх; - Систем хөгжүүлэлтийг төслийн менежментийн Agile менежментээр хийж гүйцэтгэх; - Систем хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд олон улсын жишигт нийцсэн мэдээлэл технологийн төслийн менежментийн программ хангамж ашигладаг байх, систем хөгжүүлэлтийн үйл ажиллагаа түүхчлэн хадгалагддаг байх; - Системийн хөгжүүлэлтийн кодчилол Doxegyn аргачлалаар

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
		дүрэм, стандартаар бичигддэг байх; - Системийн бичиг баримт Doxegyn аргачлалаар автоматаар гардаг байх;
9.	Ажлын хяналт, шалгалт	Захиалагчийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар гүйцэтгэнэ.
10.	Баримтын төвд хүлээлгэн өгөх материал	Баримтын төвд дараах материалыг хүлээлгэн өгнө. Үүнд: - Ажлын явцын болон эцсийн тайланг 3 хувь; - Системийн хөгжүүлэлтийн эх кодыг тоо байдлаар 3 хувь; - Техникийн болон системийн баримт бичиг, бусад холбогдох материалыг тоон болон хэвлэмэл байдлаар 3 хувь; - Мэдээлэл технологийн төслийн менежментийн программ хангамж
11.	Захиалагч	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
12.	Гүйцэтгэгч	Ижил төстэй ажил хийж гүйцэтгэж байсан ажлын туршлагатай, тухайн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэх хангалттай хүний нөөц бүхий хуулийн этгээд байх;
13.	Санхүүжилт, эх үүсвэр	200,000,000 төгрөг /Хоёр зуун сая төгрөг/; Урсгал зардал.
14.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Төрийн болон албаны нууцын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад журам, зааврын дагуу төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажлыг зохион байгуулна.
	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — А.АМАРСАЙХАН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.ХАЛИУНБИГЭР

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА — П.БАЯНТҮМЭН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Н.УРАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — А.ЭНХБААТАР

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Т.НЯМЖАРГАЛ

ГАЗРЫН ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ БОЛОН ГАЗРЫН ТӨЛБӨР ТАТВАРЫН ЦАХИМ СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Хийж гүйцэтгэх ажил		Шаардагдах зардлын тооцоо			
			Хэмжих нэгж	Хугацаа	Ажиллах хүч (хүний тоо)	Нийт зардал
1	Газрын үнэлгээний цахим системийн нэмэлт хөгжүүлэлт:	Дуудлага худалдааны анхны үнийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан тогтоол, аргачлалын дагуу тооцож, нэхэмжлэлийг үүсгэж, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх лавлагааг гаргаж үйл ажиллагааг бүрэн автоматжуулах;	хүн/ өдөр	40	9	45,262,080
		- Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх;	хүн/ өдөр	10	2	2,514,560
		- Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон нийт газарт дуудлага худалдааны анхны үнийг эрх бүхий этгээдийн шийдвэр, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан аргачлалыг үндэслэн тооцох модулийг хөгжүүлэх	хүн/ өдөр	10	2	2,514,560
		- Дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн тооцож, нэхэмжлэхийг үүсгэх, төлбөр төлсөн эсэхийг шалгах, хяналт тавих модулийг хөгжүүлэх	хүн/ өдөр	10	3	3,771,840
		- Газрын үнэлгээний цахим системээс дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх лавлагааг гаргах боломжийг бүрдүүлэх;	хүн/ өдөр	10	2	2,514,560
		Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөх олговрын болон суурь үнэлгээг тогтоох үйл ажиллагааг бүрэн автоматжуулан хэрэглэгчдэд мэдээ, мэдээллээр үйлчлэх;	хүн/ өдөр	50	12	75,436,800

		-	Иргэн, хуулийн этгээдэд газрын нөхөх олговор олгосон, тооцсон талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийн, мэдээллийн сан үүсгэх;	хүн/ өдөр	10	2	2,514,560
		-	Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговор тооцох газрыг бүртгэж баталгаажуулан газрын нөхөх олговор олгох газрын хэмжээ, байршлыг газар зүйн мэдээллийн системийн дүн шинжилгээ (geoprocessing) хийх боломжийг бүрдүүлэх;	хүн/ өдөр	10	3	3,771,840
		-	Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөх олговрын хэмжээ тогтоох, нөхөх олговрыг олгох үйл ажиллагааг бүртгэх модулийг хөгжүүлэх	хүн/ өдөр	10	3	3,771,840
		-	Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг дүйцүүлэн олгох үйл ажиллагааг Газрын үнэлгээний цахим системээр эрхлэх боломжийг бүрдүүлэх;	хүн/ өдөр	10	2	2,514,560
		-	Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөх олговрын болон суурь үнэлгээний лавлагааг гаргах боломжийг бүрдүүлэх;	хүн/ өдөр	10	2	2,514,560
			Төлөвлөлтийн нэгж талбар бүрт газрын суурь үнэ, дуудлага худалдааны анхны үнийг тооцож, харуулах;	хүн/ өдөр	5	2	1,257,280
			Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнд үндэслэн газрын зах зээлийн үнийн бүсчлэлийг харуулах;	хүн/ өдөр	10	2	2,514,560
			Газрын үнэлгээний цахим системийн үйл ажиллагааг сайжруулж, ачааллын тэнцвэржүүлэн (load balance), бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлэх;	хүн/ өдөр	10	2	2,514,560
2	Газрын төлбөр, татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт:		Газрын төлбөр, татварын цахим системийн сервер, баазын ачааллыг бууруулж, байнгын нөөцлөх үйл ажиллагааг сайжруулж, ачааллын тэнцвэржүүлэн (load balance), бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлэх;	хүн/ өдөр	15	4	7,543,680

		Ашигт малтмал, газрын тосны газраас баталсан уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Газрын төлбөрийн тухай хуулийн 7.4-т заасан төлбөрийн хувь хэмжээг тооцоолж, үйл ажиллагааг цахимжуулах;	хүн/ өдөр	15	4	7,543,680
		УИХ-аас батлагдсан Улсын хилийн зурвас газрын хил заагийг Газрын төлбөр, татварын цахим системд оруулж, хилийн зурвас газарт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөр тооцож, Газрын төлбөрийн тухай хуулийн 8.1.3-т зааснаар газрын төлбөрт хөнгөлөлт, чөлөөлөлт тооцож ногдуулах модуль хөгжүүлэх;	хүн/ өдөр	10	3	3,771,840
		Газрын төлбөр, татварын цахим системээс маш нууц давхаргад бүртгэлтэй цэргийн ангиуд болон холбогдох бусад газарт газрын төлбөрийг бодуулж, ногдуулах модулийг хөгжүүлэх;	хүн/ өдөр	15	4	7,543,680
		Газрын төлбөр, татварын цахим системээс газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн тайлан /ГНСТ-8/-г маягтын дагуу гаргах;	хүн/ өдөр	15	3	5,657,760
		Газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийн бодит цаг (real time)-аар шинэчлэлтийг хийж, төлөвийг өөрчлөх;	хүн/ өдөр	15	3	5,657,760
		Газрын төлбөр, татвартай холбоотой статистик, тоон мэдээллүүд харах цэс (view) үүсгэх, төрөл бүрийн судалгааг /нэгж талбар тус бүрээр/ системээс олон төрлийн сонголттойгоор гаргах боломжийг бүрдүүлэх;	хүн/ өдөр	10	3	3,771,840
3	Системүүдийн баримт бичгийг шинэчилж, тайлан, гарын авлага боловсруулан захиалагч талд хүлээлгэн өгөх, баталгаат хугацаанд засвар үйлчилгээг хийж хэвийн	Системүүдийн баримт бичгийг эцсийн байдлаар шинэчлэн боловсруулах;	хүн/ өдөр	10	2	2,514,560
		Хөгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгснөөс хойш 1 жилийн хугацаанд шаардлагатай нэмэлт засварыг цаг тухай бүрт нь хийх, хэвийн үйл ажиллагааг хангах:	хүн/ өдөр	10	2	2,514,560

	үйл ажиллагааг хангах:					
4	Мэргэжилтэн албан хаагчдын чадавхжуулах, холбогдох сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах:	Газрын үнэлгээний цахим систем, Газрын төлбөр, татварын цахим системийн удирдлага (admin) хэсэгт ажиллах албан хаагчдын сургах;	хүн/ өдөр	2.1	2	518,406
		21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны газрын үнэлгээ, төлбөр, газар чөлөөлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, чадавхжуулан мэргэжил арга зүйгээр хангах:	хүн/ өдөр	2	31	7,795,136
Дүн						181,818,182
Албан татвар						18,181,818
Нийт дүн						**200,000,000**

** Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар тогтоолын дагуу 2023 оны Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин өсгөсөн цалингаар буюу өдрийн 125'728 төгрөгөөр тооцов.*

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — А.АМАРСАЙХАН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.ХАЛИУНБИГЭР

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА — П.БАЯНТҮМЭН

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Н.УРАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — А.ЭНХБААТАР

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Т.НЯМЖАРГАЛ